Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2019 оны 47 тоот тушаалын
8 дугаар хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*Баталгаажуулсан:*

Тамгын газрын дарга
*(албан тушаал)*

*Тэмдэг*

***Төсвийн шууд захирагч***

............ /Ч.Алтангэрэл/
*(гарын үсэг)*

*2021-01-05*
*(огноо)*

*Нэгтгэж тайлагнасан:*

Захиргаа, удирдлагын
хэлтсийн дарга
*(албан тушаал)*

***Нэгжийн дарга***

............ /Ц.Адъяахишиг/
*(гарын үсэг)*

*2021-01-05*
*(огноо)*

ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ №1 ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, СУДАЛГАА

**Гүйцэтгэлийн зорилт №1.1.1 Хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах**

| *№1* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | *1.1.1.1 Хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд дүн шинжилгээ хийж, санал хүргүүлэх, холбогдох ажлын хэсэгт ажиллах* | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | *Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1* | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | *1-р улирал* | *2-р улирал* | *3-р улирал* | *4-р улирал* |
| | *Шаардагдах хөрөнгө* | *Үйл ажиллагааны зардлаар* | | | | |
| | *Хариуцах нэгж* | *Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс* | | | | |
| | *Суурь түвшин* | *50* | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | *Хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд өгсөн саналын тоо* | | | | |
| | *Хүрэх түвшин* | *Эхний хагас жилд - 25* | | | | |
| | | *Жилийн эцэст - 55* | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | *2020 онд хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд 189 санал боловсруулж хүргүүлэв. Үүнээс:*<br>*1 дүгээр сард:*<br>*Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл – 4 санал*<br>*4 дүгээр сард:*<br>*Коронавирустай халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төсөл - 13 санал*<br>*Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад дагалдах хуулийн төслүүд - 2 санал*<br>*5 дугаар сард:*<br>*Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл - 8 санал*<br>*6 дугаар сард:*<br>*Тусгаарлалтад байгаа сонгогчид санал өгөх боломжгүй гэсэн нотломж гаргуулах хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж буй судалж, нотломж гэсэн бичгээр тэдгээрийн сонгох эрхийг хязгаарлах нөхцөл болж байгаа талаарх санал – 1 санал*<br>*8 дугаар сард*<br>*-Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай болон холбогдох бусад хуульд "иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбогдсон зохицуулалтыг бүрдүүлэх талаарх санал (Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Ч.Ариунаа референт ажилласан) - 3 санал*<br>*-Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл - 17 санал.*<br>*-Үндэслэлгүйгээр хөрөнгөжих тухай Эрүүгийн хуулийн заалт Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалт, олон улсын гэрээтэй нийцэж буй эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд тайлбар, мэдээлэл*<br>*9 дүгээр сард*<br>*-Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд санал (НҮБ-ын холбогдох гэрээний хороод, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгэ, Тусгай илтгэгч нарын тайлангаар Монгол Улсад ирүүлсэн дүгнэлт, зөвлөмж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх жил бүрийн илтгэлүүдэд дэвшүүлсэн санал, үг илтгэлийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан, Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороогоор хэлэлцээд гаргасан тогтоол зэргийг үндэслэн боловсруулж, шинээр боловсруулах шаардлагатай, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх багц саналууд)- 77 санал*<br>*-Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл - 1 санал*<br>*-Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл - 9 санал*<br>*-Үндсэн хуулийн цэцээс ирүүлсэн тайлбар гаргуулах тухай албан бичгийн дагуу Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 1.1 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудалд дүн шинжилгээ хийж тайлбар.*<br>*12 дугаар сард*<br>*-Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл –* 35 санал | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | -Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл – 17 санал<br>-Шадар сайдын 2020 оны 99 дүгээр тушаалаар ЭМЯ дээр байгуулсан ажлын хэсэгт ХЭБСХ-ийн дарга Г.Агар-Эрдэнэ ажиллаж хилийн боомтууд, тусгаарлах байрууд дахь иргэдийн нөхцөл байдлыг үнэлэх ажлын хэсгийн 4 удаагийн хуралдаанд оролцож санал хүргүүлсэн. Шадар сайдын 2020 оны 103 дугаар тушаалаар байгуулсан “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу Засгийн газар, УОК болон бусад байгууллагын шийдвэрт дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн гишүүнээр ХЭБСХ-ийн дарга ажиллаж 8 үндэслэлээр санал хүргүүлсэн.<br>-11 сарын 25-ны өдөр УОК-т хүргүүлсэн Комиссын гишүүний 1/26 дугаартай зөвлөмжийг тус хэлтсийн боловсруулсан шуурхай үнэлгээн дээр суурилан боловсруулав.<br>Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв. | | | | |
| | Зарцуулсан хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |
| | Хүрсэн түвшин | 189 | | | | |
| №2 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.1.2 УИХ-ын чуулганаар хэлэлцэх хууль тогтоомжийн төсөл, хүний эрхтэй холбоотой бусад асуудлын талаар Комиссын гишүүд, Ажлын албыг мэдээллээр хангах | | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1 | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |
| | Хариуцах нэгж | Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс | | | | |
| | Суурь түвшин | 20 | | | | |
| | Шалгуур үзүүлэлт | 7 хоног бүрийн Даваа гарагт мэдээллээр хангасан талаарх үзүүлэлтийн тоо | | | | |
| | Хүрэх түвшин | Эхний хагас жилд – 10 | | | | |
| | | Жилийн эцэст - 20 | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт | Тайлант хугацаанд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороодоор хэлэлцэх асуудлын хуваарийг 7 хоног тутам Комиссын дарга, гишүүд, ажилтнуудад тогтмол буюу 26 удаа танилцуулав.<br>2020 оны 11 дүгээр сард ХЭҮК-т хамаарал бүхий 20 хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтын түүвэр бэлтгэж, Комиссын гишүүдэд танилцуулав. Мөн ABLE-д байршуулж, ажилтнуудыг мэдээллээр хангав.<br>Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв. | | | | |
| | Зарцуулсан хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |
| | Хүрсэн түвшин | 26 | | | | |
| №3 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.1.3 Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн орчинг бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах | | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.2 | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |
| | Хариуцах нэгж | Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс | | | | |
| | Суурь түвшин | Шинэ ажил | | | | |
| | Шалгуур үзүүлэлт | Нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад зарцуулсан цаг | | | | |
| | Хүрэх түвшин | Эхний хагас жилд – 16 | | | | |
| | | Жилийн эцэст - 16 | | | | |
| | Хэрэгжилт | 1-4 дүгээр сард хуулийн төслийг сайжруулах талаар ХЗДХЯ-тай хамтран ажиллаж, ажлын хэсгийн гишүүдийн саналыг ХЭҮК болон ХЗДХЯ дээр болсон 4 удаагийн уулзалтаар тусган хууль санаачлагчид хуулийн төслийг үзэл | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний хэрэгжилт | | *баримтлал, танилцуулга, зардлын судалгаа, үр нөлөөний судалгааны хамт хүргүүлж ажиллав. Үүнд нийт 30 цагийг зарцуулсан байна.*<br>*Ажлын хэсэг хуулийн төслийг дараах бүтэцтэйгээр шинэчлэн сайжруулж, эцэслэв. Үүнд: Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл; Хоёрдугаар бүлэг. Хүний эрх хамгаалагчийн эрх, хориглох зүйл; Гуравдугаар бүлэг. Төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хүлээх нийтлэг үүрэг; Дөрөвдүгээр бүлэг. Хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо.*<br>*Эцэслэсэн төслийг хууль санаачлагчийн хувиар УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар хуулийн төслийг 5 дугаар сард УИХ-д өргөн барьсан бөгөөд төслийг англи хэлнээ орчуулж иргэний нийгмийн байгууллагуудад түгээв. Төслийг орчуулахад нийт 13 цагийг зарцуулсан байна.*<br>*2020 оны 11 дүгээр сард УИХ-ын намрын чуулганы хуралдааны үеэр тус хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэхийн өмнө хуулийн төслийн танилцуулгыг шинэчлэн бэлтгэх болон Комиссын гишүүдэд мэдээлэл бэлтгэх ажлыг гүйцэтгэв. Үүнд 8 цагийг зарцуулсан байна.*<br>*Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв.* | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | *Үйл ажиллагааны зардлаар* | | | | |
| | *Хүрсэн түвшин* | *51 цаг* | | | | |
| *№4* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | *1.1.1.4 Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тайлан хэлэлцэхэд оролцох, холбогдох санал өгөх* | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | *Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.2* | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | *1-р улирал* | *2-р улирал* | *3-р улирал* | *4-р улирал* |
| | *Шаардагдах хөрөнгө* | *Үйл ажиллагааны зардлаар* | | | | |
| | *Хариуцах нэгж* | *Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс* | | | | |
| | *Суурь түвшин* | *Шинэ ажил* | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | *Тайлан хэлэлцэхэд оролцсон тоо* | | | | |
| | *Хүрэх түвшин* | *Эхний хагас жилд: 1* | | | | |
| | | *Жилийн эцэст: 1* | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | *Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газрын тайлаг 2022 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороогоор хэлэлцэхтэй холбоотойгоор үндэсний илтгэлийн боловсруулалтад оролцох, санал өгөхөөр төлөвлөсөн хэдий ч одоогоор Засгийн газрын зүгээс энэхүү илтгэлийг боловсруулж эхлээгүй тул уг ажлыг гүйцэтгээгүй болно.*<br>*Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрээгүй гэж дүгнэв.* | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | *Үйл ажиллагааны зардлаар* | | | | |
| | *Хүрсэн түвшин* | *0* | | | | |

**Гүйцэтгэлийн зорилт №1.1.2 Хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах**

Эрх зүйн акт: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| *№5* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | *1.1.2.1 Орон нутаг дахь эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар судалгаа явуулах* | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | *НҮБХАС-тай байгуулсан төлөвлөгөөний MEREG01R32 ажил* | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | *1-р улирал* | *2-р улирал* | *3-р улирал* | *4-р улирал* |
| | *Шаардагдах хөрөнгө* | *12,560,000 төгрөг /НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилт/* | | | | |
| | *Суурь түвшин* | *Шинэ ажил* | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | *Судалгааг явуулсан аймгийн тоо; бэлэн болсон судалгааны тайлан* | | | | |
| | *Хариуцах нэгж* | *Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс* | | | | |
| | *Хүрэх түвшин* | *Эхний хагас жилд: 6; 1* | | | | |
| | | *Жилийн эцэст: 6; 1* | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт | 2020 оны 3, 4 дүгээр сард үнэлгээний удирдамж, асуулгыг боловсруулж батлуулав. Ингэхдээ үнэлгээг дараах асуудалд төвлөрч хийхээр удирдамжийг боловсруулсан болно. Үүнд:<br>- Бүс нутаг дахь эмэгтэйчүүдийн бэлгийн боловсрол, жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслийн талаарх мэдээллийн хүртээмж;<br>- Жирэмсэн эхэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үр зулбалт, үр хөндөлтийн нөхцөл байдал;<br>- ХДХВ/ДОХ болон бэлгийн замаар дамжих халдварт өвчний гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;<br>- Бэлгийн хүчирхийллийн асуудал.<br>6 сард Дорноговь, Дорнод, Орхон, Сүхбаатар, Дархан-Уул, Булган, Говьсүмбэр, 9 сард Өмнөговь, нийт 8 аймгийн хэмжээнд уул уурхайн бүсийн эмэгтэйчүүдийг зорилтот бүлэг болгон сонгож үнэлгээг явуулав. Үнэлгээний ажлын хүрээнд орон нутгийн аймаг, сумдын удирдлага, аймгуудын Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, Соёл Урлагийн газраас холбогдох мэдээллийг авахын зэрэгцээ нөхөн үржихүйн насны 20-иос доошгүй охид, эмэгтэйчүүд (15-49 насны)-тэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, санал асуулга авч ажиллалаа.<br>11 сард судалгааны хүрээнд аймгуудаас авсан санал асуулгын дүнг нэгтгэх, төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нягтлах, тайлангийн төсөлд тусгах ажлуудыг хийж, үнэлгээний тайланг НҮБХАС руу хүргүүлэв.<br>Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв. | | | | |
| | Зарцуулсан хөрөнгө | НҮБХАС санхүүжилтээр | | | | |
| | Хүрсэн түвшин | 7; 1 | | | | |
| №6 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.2.2 Орон нутаг дахь эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар явуулсан судалгааны дүнг танилцуулах уулзалт зохион байгуулах | | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1 | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | 3,400,000 төгрөг /НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилт/ | | | | |
| | Хариуцах нэгж | Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс | | | | |
| | Суурь түвшин | 0 | | | | |
| | Шалгуур үзүүлэлт | Уулзалтад оролцсон төрийн болон төрийн бус байгууллагын оролцогчдын тоо | | | | |
| | Хүрэх түвшин | Эхний хагас жилд: 0 | | | | |
| | | Жилийн эцэст: 35 | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт | Ковид-19 цар тахлын улмаас өндөржүүлсэн болон бүхий нийтийн бэлэн байдлын зэрэгүүдэд шилжсэн тул НҮБХАС-тай зөвшилцсөний дагуу 2021 оны 1-р улиралд олон талт төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг танилцуулахаар болсон. | | | | |
| | Зарцуулсан хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |
| | Хүрсэн түвшин | 0 | | | | |
| №7 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.2.3 Хууль тогтоомжид заасан аргачлалын дагуу УАБЗ-д холбогдох судалгааг хүргүүлэх, мэдээллээр хангах | | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1 | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |
| | Хариуцах нэгж | Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс | | | | |
| | Суурь түвшин | 4 | | | | |
| | Шалгуур үзүүлэлт | Улирал тутам хүргүүлсэн танилцуулга бүхий мэдээллийн тоо | | | | |
| | Хүрэх түвшин | Эхний хагас жилд: 2 | | | | |
| | | Жилийн эцэст: 4 | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт | Нэдүгээр улирлын танилцуулах мэдээг УАБЗ-д 4 дүгээр сард хүргүүлэв. Энэ удаагийн ээлжит танилцуулга мэдээг Монгол Улсын Их Хурлад өргөн барьдаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлээр дэвшүүлсэн санал зөвлөмжийн хүрээнд боловсруулав.<br>5 сард УАБЗ-д хүргүүлсэн тайлан мэдээг 2018-2020 оны байдлаар шүүж, УИХТГ-т хүргүүлэн, хувийг мөн УАБЗ-д хүргүүлэв.<br>Хоёрдугаар улиралд хүний эрх, эрх чөлөөний асуудлаар хууль тогтоомж, нөхцөл байдлын цогц судалгаа шинжилгээ хийж байгаа талаар дараах 2 сэдвийн хүрээнд мэдээлэл бэлтгэж УАБЗ-д хүргүүлэв. Үүнд:<br>1. Туслах малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, тэдний хүний эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны ажил гүйцэтгэх;<br>2. Уул уурхайн бүс нутагт оршин сууж буй охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийх;<br>Гуравдугаар улиралд УАБЗ-д дараах асуудлаар мэдээлэл бэлтгэж хүргүүллээ.Үүнд:<br>- "Туслах малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хүний эрхийн хэрэгжилт" судалгааны тайлангийн явцын мэдээлэл;<br>- Уул уурхайн бүс нутагт оршин сууж буй охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтэд үнэлгээний тайлангийн явцын мэдээлэл;<br>- Улсын Их Хурлын ээлжит сонгуультай холбогдуулан олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан сонгуулийн эрх бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийг хангах хүрээнд сонгуулийн санал авах байр тэдгээр иргэдэд хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн эсэхэд хийсэн мониторингийн үр дүнгийн талаарх мэдээлэл;<br>- Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхэд хэрхэн нөлөөлж байгаад хийсэн хяналт шалгалтын мэдээлэл;<br>- Төрийн албаны үйлчилгээ, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт шалгалтын мэдээлэл.<br>Дөрөвдүгээр улиралд Ковид-19 цар тахалтай холбоотой асуудлаар танилцуулга мэдээг хүргүүлэхээр бэлтгэв.<br>Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв. | | | | |
| | Зарцуулсан хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |
| | Хүрсэн түвшин | 4 | | | | |
| №8 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.2.4 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах | | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | НҮБХАС-тай байгуулсан төлөвлөгөөний ADVOC01R32 ажил | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | 9.000.000 НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр | | | | |
| | Хариуцах нэгж | Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс | | | | |
| | Суурь түвшин | 0 | | | | |
| | Шалгуур үзүүлэлт | Уулзалтад оролцсон төрийн болон төрийн бус байгууллагын тоо | | | | |
| | Хүрэх түвшин | Эхний хагас жилд: 0 | | | | |
| | | Жилийн эцэст: 100 | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт | Ковид цар тахлын улмаас тус ажлыг НҮБ-ын Хүн амын сантай тохиролцож 2021 оны 1 дүгээр улиралд хийхээр хойшлуулсан бөгөөд Комиссын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан болно. | | | | |
| | Зарцуулсан хөрөнгө | | | | | |
| | Хүрсэн түвшин | 0 | | | | |
| №9 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | | |
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.2.5 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн судалгааг 2019 оны үзүүлэлтээр гаргаж шинэчлэх, УАБЗ-д хүргүүлэх | | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1 | | | | |
| | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | | | | |

<table>
<tr><td rowspan="5">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">1</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">ЦЕГ, УЕПГ-аас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан гаргасан судалгаа</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд: 1</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст: 1</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Судалгааг 2018 болон 2019 оны үзүүлэлттэй харьцуулан гүйцэтгэж Комиссын удирдлагад танилцуулж, цахим номын санд нээлттэй байршуулав. Судалгааны хүрээнд ЦЕГ, УЕПГ-аас тус тус мэдээлэл гаргуулан авч, 2018, 2019 онд хийсэн ижил төрлийн судалгаатай дүн мэдээллийг харьцуулан судалж гүйцэтгэв.<br>Судалгааны тоймоос дурдвал:<br>ЦЕГ-аас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2019 онд улсын хэмжээнд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийт 610 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 10 тохиолдлоор буурсан үзүүлэлт юм. Мөн уг төрлийн гэмт хэргийн гаралт буурсан хэдий ч 18 насанд хүрээгүй хүүхдүүд хохирогчоор бүртгэгдэх тохиолдол нэмэгдсээр байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 12-р бүлэгт заасан “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-т 2018 онд 579 хохирогч бүртгэгдсэнээс 312 нь хүүхэд байсан бол 2019 онд 624 хохирогч бүртгэгдсэнээс 359 нь хүүхэд байна.<br>Эрүүгийн хуулийн 12-р бүлгийг зүйл бүрээр нарийвчлан авч үзвэл, 2019 онд хүчиндэх (ЭХ-ийн §12.1) гэмт хэргийн 492 хохирогчийн 253 нь, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (ЭХ-ийн §12.2) гэмт хэргийн 5 хохирогчийн 3 нь, бэлгийн мөлжлөг (ЭХ-ийн §12.3) гэмт хэргийн 6 хохирогчийн 4 нь хүүхэд байна. Харин арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (ЭХ-ийн §12.5) гэмт хэргийн хохирогч 99 хүүхэд байна.<br>Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нь хүүхдийн бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 76.2 хувийг эзэлж байсан бол 2019 онд 78.8 хувийг эзэлж байна гэж, харин Улсын Ерөнхий прокурорын газраас 2018 онд дээрх тоо 76.4 хувь байсан бол 2019 онд дээрх тоо 43.3 хувь болсон хэмээн тус тус мэдээлсэн байна. Эрүүгийн хуулийн §12.5-т заасан гэмт хэргийн хувь огцом (Бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 55.3 хувь) нэмэгдсэн нь дээр дурдсанчлан Улсын Ерөнхий Прокурорын газраас явуулсан шалгалтын дүнтэй холбоотой юм.<br>Хохирогч хүүхдүүдийн насны ангиллыг харгалзан үзэхэд, 13-15 насны хүүхдүүд дийлэнх хувийг эзэлж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд 18-45 насныхан хүчиндэх гэмт хэрэгт яллагдагчаар илүүтэй татагдан шалгагдсан байна. Тухайлбал, 2018 онд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан 251 хүчиндэх гэмт хэргийн 62-т нь 18-25 насны хүмүүс, 89-д нь 26-45 насны хүмүүс яллагдагчаар, 2019 онд 267 хүчиндэх гэмт хэргийн 35-д нь 18-25 насны хүмүүс, 54-т нь 26-45 насны хүмүүс яллагдагчаар тус тус татагдсан байна.<br>Харин 2018 онд хүүхэдтэй холбоотой хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг хэрэгт 29 хүүхэд (нийт яллагдагчдын 12.5 хувь), 2019 онд 17 хүүхэд (нийт яллагдагчдын 15.1 хувь) яллагдагчаар татагдан шалгагдсан ба 2018 онд хохирогчоор тогтоогдсон хүүхдүүдийн хамгийн бага нь 1 настай байсан бол 2019 онд хохирогчоор тогтоогдсон хүүхдийн хамгийн бага нь 2 настай байна.<br>Дэлгэрэнгүй судалгааг үзэх линк: https://lib4u.net/ebook/?id=167&lib=nhrc<br>Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">Үйл ажиллагааны зардлаар</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">1</td></tr>
<tr><td>№10</td><td colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">1.1.2.6 Туслах малчдын хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, хувийн халдашгүй байдал, оролцооны эрхийн асуудлаарх судалгааг гүйцэтгүүлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Европын холбооны санхүүжилтийн гэрээ EuropeAid/162989/DD/ACT/MN</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">EIDHR/2019/162989/9 Төслийн санхүүжилт</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">Шинэ ажил</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Төлөвлөгөөний дагуу боловсруулсан санал асуулга, гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан судалгааны ажлын гэрээ</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд: 1</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст: 1</td></tr>
<tr><td></td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Судалгааны ажлын гүйцэтгэгчийг хөндлөнгийн, хараат бус үнэлгээний баг сонгон шалгаруулж, IRIM судалгааны байгууллагатай гэрээ байгуулсан болно. Энэ ажлын хүрээнд гүйцэтгэгч байгууллагатай байгуулах судалгааны ажлын удирдамжийн</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| Арга хэмжээний хэрэгжилт | | *төсөл, ажлын даалгавар, зөвлөх үйлчилгээний гэрээний төсөлд санал өгөх, хөндлөнгийн мониторингийн заавар боловсруулах ажлыг хийв.*<br>*Мөн судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг сонгогдсон 6 аймагт зохион байгуулахаас өмнө судлаачдад зориулсан сургалт зохион байгуулахад судалгааны зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүнгийн талаар нэгдсэн ойлголт өгөх зорилгоор зохион байгуулсан сургалтад хөдөлмөрлөх эрх, албадан хөдөлмөрөөс ангид байх талаар суурь ойлголтуудыг өгч ажиллав.*<br>*IRIM судалгааны хүрээлэнгийн судлаачдад малчдын эрхтэй холбоотой судалгаа шинжилгээний материалуудыг имэйлээр хүргүүлж, судалгааны тайлангийн эхний боловсруулалтад холбогдох саналаа гаргав. Мөн тус судалгааны хүрээлэнгийн талбарын судлаачид хийх уулзалтад 10 дугаар сарын 9-ний өдрийн оролцож, санал солилцов.*<br>*Судалгааны тайланг 11 дүгээр сард гүйцэтгэгч байгууллагаас хүлээн авсан ба нэмэлт сайжруулалт хийх саналыг төслийн багын зүгээс гаргаж, уг саналуудын дагуу дахин сайжруулалтыг хийж байна.*<br>*Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрэх шатанд гэж дүгнэв.* |
| | *Зарцуулсан хөрөнгө* | *EIDHR/2019/162989/9* |
| | *Хүрсэн түвшин* | *80 хувь* |

**Гүйцэтгэлийн зорилт № 1.1.3 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бичих**
Эрх зүйн акт: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3

| *№11* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | *1.1.3.1 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийг боловсруулах, УИХ-д өргөн барих* | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | *Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1* | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | *1-р улирал* | *2-р улирал* | *3-р улирал* | *4-р улирал* |
| | *Шаардагдах хөрөнгө* | *Үйл ажиллагааны зардлаар* | | | | |
| | *Хариуцах нэгж* | *Тамгын газар* | | | | |
| | *Суурь түвшин* | 1 | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | Илтгэлийн холбогдох бүлгийг хугацаанд нь боловсруулсан эсэх | | | | |
| | *Хүрэх түвшин* | *Эхний хагас жилд: 1* | | | | |
| | | *Жилийн эцэст:1* | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | *Илтгэлийг 1-3 дугаар саруудад боловсруулж, 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барив. Энэхүү ээлжит илтгэлийг үндсэн 4 сэдвийн хүрээнд боловсруулж, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 болон 17 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар 23 саналыг тусгасан болно.*<br>*Тухайлбал, 2019 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр алслагдсан аймаг, сум дахь малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтийг судлан "Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдал: хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал" сэдэвт нэгдүгээр бүлгийг боловсруулсан байна. Энэ хүрээнд "Аймаг сум, багийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэх, төсвийг ИТХ нь шийдвэрлэдэг байх", "жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээг алслагдсан сум, багийн эмэгтэйчүүдэд хүргэх, зайлшгүй тохиолдолд аймгийн төвөөс алслагдсан газарт амьдарч буй жирэмсэн эмэгтэйчүүдийг сумандаа амаржих нөхцөлөөр хангах" зэрэг 13 саналыг тусгав.*<br>*19 дэх илтгэлийн хоёрдугаар бүлгийг "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт" сэдвийн хүрээнд боловсруулжээ. Улсын хэмжээнд 160 байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, энэ хүрээнд 1,681 төрийн албан хаагчаас авсан судалгааны санал асуулгын нэгтгэсэн дүн, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага болон холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, баримт, мэдээлэлд тулгуурлан дээрх бүлгийг боловсруулсан байна. Сэдвийн хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар Ерөнхий сайдын албан даалгавар гаргаж, аймгуудын Засаг дарга нарт хүргүүлэх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгох зэрэг 6 саналыг тусгав.* | | | | | |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="5">Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэлд хүргэх үйлчилгээтэй, тэсрэмтгий, шатамхай, исэлдүүлэгч, идэмхий, цочроогч шинж чанартай химийн хорт болон аюултай бодисыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэдэг. Улмаар хугацаа нь дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, удаан хугацаанд хадгалагдсан химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, хамгаалах, зайлуулах, устгах асуудал тулгамдаад буй. Иймд химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтад төрөөс анхаарал хандуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагын үүднээс Комиссоос хийсэн хяналт шалгалт, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, холбогдох эрх бүхий байгууллагын судалгаа, баримт, мэдээлэлд үндэслэн “Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтын талаар тулгамдаж буй зарим асуудал” сэдвийн хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийн гуравдугаар бүлгийг боловсруулжээ. Энэ хүрээнд хот суурин газарт сургууль, эмнэлэг, лаборатори, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд олон жил хуримтлагдаж хадгалагдаж байгаа, хугацаа нь дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлыг байршуулах, хадгалах зориулалтын барилга, байгууламжийг яаралтай бий болгох, химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар устгах үйлдвэрийг барих асуудлыг нэн даруй шийдвэрлэх зэрэг 4 саналыг тусгав.<br><br>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын мэдээлэл бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдад хүрч холбогдох шийдвэр гарч ирсний зэрэгцээ олон нийт ч улс орны хүний эрхийн төлөв байдал олон улсын түвшинд ямар байгаа, улс орнуудын дунд ямар байр эзэлж байгаа талаар ач холбогдол өгөн анхаарч, мэдээлэл хайдаг болжээ. Иймд Комисс улс орнуудыг нийгмийн болон хүний хөгжлийн түвшингээр нь тодорхой шалгуураар үнэлж оноо өгдөг, индексжүүлэн эрэмбэлдэг олон улсын байгууллага, судалгаа шинжилгээний төвүүдээс гаргасан тайлан мэдээллээс хүний эрхэд холбогдох индексийг түүвэрлэн, зарим эрхийн хүрээнд нэгтгэн 19 дэх илтгэлийн “Хүний эрхийн олон улсын индекс ба Монгол Улсын эзлэх байр” сэдэвт дөрөвдүгээр бүлэгт тусгав.<br><br>Илтгэлийг 12 дугаар сард УИХ-ын НББХ-оор хэлэлцсэн ч, тайлант хугацаанд УИХ-аар хэлэлцэж шийдвэр гаргаагүй байна.<br><br>Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв.</td></tr>
<tr><td></td><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">Үйл ажиллагааны зардлаар</td></tr>
<tr><td></td><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">1</td></tr>
<tr><td>№12</td><td colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">1.1.3.2 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийг англи хэл рүү орчуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">НҮБХАС-ийн төслийн санхүүжилт 7,000,000 төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">Олон улсын гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтэс</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">1</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Илтгэлийг хугацаанд нь багтаан орчуулж, хянуулсан байх</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд: 1</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст: 1</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Илтгэлийг 2 дугаар улиралд багтаан орчуулж, хяналт хийв.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">НҮБХАС-ийн төслийн санхүүжилт 7,000,000 төгрөг</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">1</td></tr>
<tr><td>№13</td><td colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">1.1.3.3 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийг монгол, англи хэл дээр хэвлүүлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1</td></tr>
<tr><td rowspan="2"></td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">6,600,000 төгрөг</td></tr>
</table>

<table>
<tr><td rowspan="5">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2500</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Техникийн алдаагүй, чанарын шаардлага хангасан хэвлэлтийн хувь</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд: 2300</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст: 2300</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Илтгэлийн монгол хэл дээрх хувийг 4 сард хяналтын уншлага, эх бэлтгэлийг хийж “Мөнхийн үсэг” ХХК-д 2,000 хувь хэвлүүлэв.<br>Англи хэл дээрх илтгэлийг орчуулга хийгдэж дуусмагц хэвлэлтэд шилжүүлж, 7 сарын 6-ны өдөр 300 хувь хэвлэлтээс хүлээн авав.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">4,200,000 төгрөг</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">2300</td></tr>
<tr><td>№14</td><td colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">1.1.3.4 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийг цахим хуудаст нийтлэх, сурталчлах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">Үйл ажиллагааны зардлаар</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">Захиргаа удирдлагын хэлтэс</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Илтгэлийг Комиссын вэб сайтад байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд: 1,10</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст: 1,10</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Илтгэлийг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн барьсан талаарх мэдээллийг бэлтгэж Комиссын цахим хуудас, нийгмийн сүлжээний хуудас болон бусад хэвлэл мэдээллийн болон нийгмийн сүлжээний 20 орчим хэрэгслээр сурталчлав.<br>Илтгэлийг сурталчилах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний дагуу илтгэлийн сэдвүүдийн хүрээнд холбогдох албан тушаалтан, албан хаагч нар хэвлэл мэдээллийн дараах 9 хэрэгслээр ярилцлага өгсөн болно. Тухайлбал:<br>1. peak.mn сайт “Аюулын харанга дэлдсэн химийн бодисын хэрэглээ” нийтлэл<br>2. zaluu.com сайт “Нөхөр зодож, нүд рүү униар хатгаснаас болж харааны бэрхшээлтэй болсон”<br>3. “Ардчилал таймс” сонин “Малчин эмэгтэйчүүдийн асуудал”<br>4. Urug.mn сайт “ХЭҮК: 16 нас хүрээгүй хүүхдийг туслах малчнаар ажиллуулахгүй байхаар хуульчлах хэрэгтэй<br>5. “Малчин эмэгтэйчүүд хүчирхийллийн золиос болж байна” нийтлэл<br>6. Засгийн газрын мэдээ” сонин “Боловсролгүй эрчүүд олширч байгаа нь боегтлох ёс сэргэхэд хүргэв үү”<br>7. МҮОНТВ-ийн ММ, “Цагийн хүрд” “Хүний эрхийн илтгэлийг өргөн барилаа”<br>8. shudarga.mn сайт 19 дэх илтгэлийг өргөн барилаа<br>9. ETV телевиз Илтгэл өргөн барилаа<br><br>Мөн Баянхонгор, Баян-Өлгий, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Өмнөговь, Төв, Увс, Завхан 9 аймгийн орон нутгийн ажилтнууд орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хуудсаар сурталчилгаа хийв. Тухайлбал, Баян-Өлгийн аймгийн ажилтан орон нутгийн радиогийн зочны цаг хөтөлбөрт “Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдал” сэдвээр, Сүхбаатар аймгийн ажилтан аймгийн Гэр бүлийн радио 104.0-ийн зочны цаг 30 минутын шууд нэвтрүүлэгт 2020 оны 04 сарын 22-ны өдөр оролцож “Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдал, хүчирхийлэлэс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал” сэдвээр 2020 оны 04-р сарын 29-ны өдөр “Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт хамгаалалтын талаар тулгамдаж буй зарим асуудал” сэдвээр тус тус мэдээлэл өгсөн. Мөн “Сүхбаатарын өнгө” орон нутгийн сонинд “Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт хамгаалалтын талаар тулгамдаж буй зарим асуудал” сэдвээр нийтлэл бэлтгэж хэвлүүлсэн байна.<br>Иймд тус арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">1,19</td></tr>
</table>

| №15 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.3.5 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудад түгээх | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.1 | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | 1,000,000 төгрөг | | | |
| | Хариуцах нэгж | Захиргаа удирдлагын хэлтэс | | | |
| | Суурь түвшин | 900 | | | |
| | Шалгуур үзүүлэлт | Холбогдох байгууллагуудад хүргүүлсэн илтгэлийн тоо | | | |
| | Хүрэх түвшин | Эхний хагас жилд: 650 | | | |
| | | Жилийн эцэст: 1000 | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл 2000 ширхэгийг хэвлүүлж, түгээх хуваарийг гарган нийт 86 байгууллагад 1034 илтгэлийг түгээсэн байна. Үүнд:<br>- Төрийн байгууллага 61<br>- Эрдэм шинжилгээний байгууллага 23<br>- Төрийн бус байгууллага 2<br>- Шинжлэх ухааны академийн 5 хүрээлэнгээс 3 хүрээлэнд өгсөн.<br>- Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд 426 ширхэг түгээв.<br>Үлдэгдэл 545 ширхэг байна. | | | |
| | Зарцуулсан хөрөнгө | | | | |
| | Хүрсэн түвшин | 1034 | | | |

**Гүйцэтгэлийн зорилт № 1.1.4 Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах**

Эрх зүйн акт: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4

| №16 | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | 1.1.4.1 Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах сэдэвчилсэн аян өрнүүлэх | | | | |
| | Төлөвлөлтийн уялдаа: | Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 1, Зорилт 1.2 | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | Шаардагдах хөрөнгө | 4,000,000 төгрөг | | | |
| | Хариуцах нэгж | Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс | | | |
| | Суурь түвшин | Шинэ ажил | | | |
| | Шалгуур үзүүлэлт | Баталсан хуваарийн дагуу аянг зохион байгуулсан байх | | | |
| | Хүрэх түвшин | Эхний хагас жилд: 0 | | | |
| | | Жилийн эцэст: 1 | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт | "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-д заасан эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн чиглэлээр Ковид-19 өвчнөөс сэргийлэх агуулга бүхий 3 төрлийн шторкийг бэлтгэж түгээв. Видеонд урлаг, соёлын салбарын төлөөллийг Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран оролцуулав. Шторкуудыг МҮОНТ-ээр Цагийн хүрд нэвтрүүлгийн өмнө болон хойно 3 дугаар сард нийт 24 удаа цацалтыг төлбөргүй хийлгэв. Мөн 2020 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийг дуустал 21 хоногийн хугацаанд Комиссын нийгмийн сүлжээний хуудсаар 3 шторкийг төлбөртэй явуулж сурталчлав. Төлбөртэй пост дахь нэг видеог дунджаар 30,000 хүн үзсэн байна.<br>Үзэх линк:<br>Видео 1 https://www.youtube.com/watch?v=m2A9_PX0fo4<br>Видео 2 https://www.youtube.com/watch?v=jo-NcxNYNGQ<br>Видео 3 https://www.youtube.com/watch?v=V26Os2UtR6w<br>"Скаймедиа Корпораци"-тай байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Комиссоос бэлтгэсэн "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" постеруудыг IPTV-гийн Bootscreen-д 30 сарын хугацаанд байршуулж ажиллахаар болсон. Постеруудыг хэвтээ хэлбэрт буюу IPTV-гийн өргөн дэлгэцийн форматад хувирах ажлуудыг үе шаттай хийв. Мөн Комиссоос бэлтгэсэн 3 видео хичээл, 7 шторкийг видео санд | | | |

<table>
<tr><td rowspan="3"></td><td></td><td colspan="5">байршуулж, “Хүний эрхийн боловсрол” санг ажиллуулж эхлэв. Тус санд хүний эрхийн чиглэлийн 26 киног сонгон авч байршуулав.<br>Арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэв.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">3 шторкийг бэлтгэхэд 1,000,000 сая төгрөг, нийгмийн сүлжээгээр цацалт хийхэд 254,000 төгрөг, нийт 1,254,000 төгрөг зарцуулав.</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">1</td></tr>
<tr><td>№17</td><td colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">1.1.4.2 Хүний эрхийн олон улсын өдрийн арга хэмжээг зохион байгуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Комиссын стратеги төлөвлөгөөний Зорилго 3, Зорилт 3.1</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">7,050,000 төгрөг болон Нэмэлт санхүүжилтээр</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">Тамгын газар</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">1</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Баталсан хуваарийн дагуу аянг зохион байгуулсан байх</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд: 0</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст: 1</td></tr>
